



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/433

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 294 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эх, багш ажилчдын хандивласан нийт 3,648,000.00 (гурван сая зургаан зуун дөчин найман мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 294 дүгээр цэцэрлэг (Д.Оюунтүлхүүр)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 294 дүгээр цэцэрлэг (Д.Оюунтүлхүүр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.Оюумаа

В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны
өдрийн 11/11 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: 294-р цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
							нэгжийн үнэ	нийт дүн		
2	Бүтээлийн тавиур	Цагаан өнгийн ДСП хавтан 5 давхар тавиуртай	2024	Сайн	ш	2	450,000.00	900,000.00	Деваторг ХХК, Тушиг ХХК	багш ажиллагсдын хандив
3	Шкаф /ЗАН/	Цагаан өнгийн ДСП хавтан дээр дороо хаалгатай, голдоо 3 давхар тавиуртай	2024	Сайн	ш	1	1,378,000.00	1,378,000.00	Кантин трейд ХХК	багш ажиллагсдын хандив
4	Хувцасны шүүгээ	Цагаан өнгийн ДСП хавтан нарийхан дээрээ хаалгатай	2024	Сайн	ш	1	270,000.00	270,000.00	ВТ вакуум ХХК	Эцэг эхийн хандив
5	Бүтээлийн тавиур	Цагаан өнгийн ДСП хавтан 4 тавиуртай	2024	Сайн	ш	1	400,000.00	400,000.00	ВТ вакуум ХХК	Эцэг эхийн хандив
6	Номын үзүүлэнгийн тавиур	Цагаан өнгийн ДСП хавтан 1 тавиуртай	2024	Сайн	ш	1	150,000.00	150,000.00	Саруул ноён ХХК	Эцэг эхийн хандив

7	Багшийн шкаф	Цагаан өнгийн ДСП хавтан 2 хаалгатай	2024	Сайн	ш	1	200,000.00	200,000.00	Саруул ноён ХХК	Эцэг эхийн хандив
8	Бүтээлийн тавиур	Цагаан өнгийн ДСП хавтан 5 тавиуртай	2024	Сайн	ш	1	350,000.00	350,000.00	Деваторг ХХК	багш ажиллагсдын хандив
Нийт								3,648,000.00		